



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/МЗ1

Мандагговь

Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон
импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний
жагсаалтын хэрэгжилт хангах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.н, 29.1.6.а, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А-429/257 “Жагсаалт батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”-ыг нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж, бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодол, үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, хоёрдогч түүхий эд худалдан авах цэг болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, хогийн цэгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай гэрээ байгуулан ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт даалгасугай.

2. Захирамжийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

431210623